



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 04 сарын 06 өдөр

Дугаар А/129

Мандалговь

Г Ажлын хэсэг байгуулах тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4 "д", Эрчим хүчний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Дундговь аймгийн төвд шинээр баригдах дулааны станцын 2 дугаар хэлхээний төсөв, судалгааг боловсруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:	Н.Эрдэнэ-Очир	/Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга/
Нарийн бичгийн дарга:	О.Мөнхзул	/Аймгийн ЗДТГазрын Хөрөнгө, оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн/
Гишүүд:	Б.Рэнцэндорж	/Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Газрын удирдлагын хэлтсийн дарга/
	А.Бямбаа	/Мандал харш ХХК-ний төсөвчин/
	Н.Эрдэнэбат	/Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн мэргэжилтэн/
	Э.Энхмэнд	/Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн мэргэжилтэн/
	Б.Золжаргал	/Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын Эрчим хүч, харилцаа холбооны хяналтын улсын байцаагч/
	Б.Уламбаяр	/“Дундговь-Ус” ОНӨҮГ-ын ашиглалтын инженер/
Б.Зоригт-Эрдэнэ	/“Ган-Илч” ХХК-ний гүйцэтгэх ерөнхий инженер/	
Б.Батнаран	/Тэвшийнговь ХХК-ний менежер/	
Н.Батдэлгэр	/Ариун болор ХХК-ний захирал/	

Хоёр. Ажлын хэсгийн хийх ажлын удирдамжийг хавсралтаар баталсугай.

Гурав. Удирдамжийн дагуу төсөв, судалгааг гаргаж, аймгийн Засаг даргад танилцуулахыг ажлын хэсэг /Н.Эрдэнэ-Очир/-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

Аймгийн Засаг даргын 2018 оны
04-р сарын 06 өдрийн А/124
дугаартай захирамжийн
хавсралт

**ШИНЭЭР БАРИГДАХ ДУЛААНЫ СТАНЦЫН 2 ДУГААР ХЭЛХЭЭНИЙ ТАЛААР
ХИЙХ АЖЛЫН УДИРДАМЖ**

Зорилго: Хүн амын амьдрах тав тухтай эрүүл, аюулгүй орчин бүрдүүлж, дулаан, халуун усны хангалтыг тасралтгүй, найдвартай хангахад оршино.

Хамрах хүрээ: Аймгийн төвд үйл ажиллагаа явуулж буй бүх албан байгууллага, аж ахуйн нэгж, айл өрхийн барилга байгууламжийг төвлөрсөн дулаан, хэрэглээний халуун усны хангамжи д холбох

Хугацаа: 2018 оны 04 дүгээр сарын 16-ны дотор судалгаа, төсөв гаргасан байх.

Гарах үр дүн:

1. Аймгийн төвд байгаа нам даралтын халаалтын зуухнууд байхгүй болсноор агаарын бохирдол багасах, хүн ам ая тухтай орчинд амьдрах.
2. Хэрэглээний халуун устай болсноор хүн амын ариун цэвэр, эрүүл ахуйн орчин сайжрах.

Хийх ажил:

1. Улсын болон хувийн байгууллага, айл өрх дулааны станцад холбогдох саналыг албан бичгээр авах. /Шугам сүлжээний боломжийг харгалзан бүгдийг холбох/
2. Хэрэглээний халуун усны шугам сүлжээтэй албан байгууллага, аж ахуй нэгж, орон сууц, айл өрхийн судалгааг гаргах.
3. Одоо байгаа 2 дугаар хэлхээний шаардлага хангахгүй халаалтын шугам сүлжээний судалгаа тооцоог гаргах.
4. Шинээр төлөвлөж буй ус дулаан дамжуулах төвөөс одоо байгаа уурын зуухнуудад /2-р хэлхээнд/ холбох болон өөрсдөө галлагаатай байгууллагын 2 дугаар хэлхээний хэрэглээний халуун ус, халаалтын шугам сүлжээний шугам сүлжээний тойм зураг боловсруулах.
5. Улсын болон хувийн байгууллага, орон сууц, айл өрхийн хэрэглээний халуун усны шугам шинээр тавих болон халаалтын шугам сүлжээний засварлах, шинээр тавих төсвийг тус тусад нь гаргах.